

Орон бүхний пролетарийн нар нэгдэгчүү! АНХ ДУГААР ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ № 57 (2321) 1974 оны 7 дугаар сарын 31 ЛХАГВА

МАЛЧИН ЗАЛУУЧУУДЫН ЧУХАЛ ЗОРИЛТ

Манай орны эдийн засгийн чухал үндэс мал аж ахуйн байнгын өсөлтийг хангахад залуу малчдын гүйцэтгэл байгаа үүрэг асар их юм.

Зөвхөн аймгийн хэмжээгээр авч үзэхэд залуучууд нийт мал сүргийн тавны нэгийг хариуцан маллаж, өсгөн үржүүлж байна.

Тэд ахмад тэргүүний малчдын туршлагаас цугалтгүй суралцаж мал маллаах арга барилыг шаргуу эзэмшиж, тодоор нь малаа өсгөх зорилт дэвшүүлэн ажиллаж байгаа билээ.

Энэ онд эвлэлийн гишүүд, залуучууд 182.1 мянган мал хариуцан төлүүлж, гарсан төлийн 99,6 хувийг бойжуулсны дээр залуучуудын 128 суурь энх төлчин, 263 суурь 100 эхээс бойжуулах төлийн талаар МХЗЭ-ийн Төв Хорооны VI бүгд хурлын шийдвэрийг биелүүллээ. Одоо малчин залуучууд 283.1 мянган малыг отроор таргалуулж, Угтаал, Баянжаргалан, Эрдэнэсант, Луи, Баянцогт, Баян-Өнжүүл сумдын эвлэлийн байгууллагууд гишүүд залуучуудын хүчийг төл бүрэн авах, мал сүргийг таргалуулахад чиглүүлэн ажилласнаар зохих амжилтад хүрлээ.

Малчин залуусын өнөөгийн гол зорилт нь тэргүүний малчдын туршлагыг хэрэглэн зүй, нарийн цагт малыг бэлчээрээр таргалуулах явдал юм.

Юуны өмнө нийт малаа зоо-мал эмнэлгийн үзлэг хийж алейн болон ойрын оторт гарах, оторт нүүдлийн зураглал гаргах, мал сүргээ таргалуулах талаар уралдаанд үүрэг авах, хувийн бэлтгэлийг урьдчилж хангасан байх нь чухал байна.

Эвлэлийн байгууллагууд зүй, нарийн отрыг чадварлаг зохион байгуулах, малчин залуучуудын дунд "Зузаан тарга—хуяг", "тарган мал тал бүрийн ашигтай", "Хавтай уаирын нэг цагт хатуу улирлын хоёр цагийн ноц хуримтлуулах" гэсэн уриан дор мал таргалуулах хөдөлгөөнийг өрнүүлэн ажиллавал зохино.

Оторт гарах мал сүргийг нүүлсний үндсэн дээр хэдий хугацаанд хэдэн цаг-аар малаа таргалуулах талаар малчин, суурь бүрт тодорхой үүрэг даалгавар өгөх, тарга хүчний нэмэгдлээс олох аж ахуйн ашиг, малчин авах нэмэгдэл хөлө, урамшүүдэлт зэргийг залуучууд бүрт сайн ойлгуулах нь отроор мал таргалуулах ажлын амжилтыг ихээхэн ахиулна.

Мал оторлох бэлчээрийн өвс ургамлын гарц тодорол хүрэлцээг урьдчилан судалж, тэнд ямар төрлийн хэд хичнээн суурь хэдий хугацаагаар оторлож болох талаар залуу малчдад зөвлөлтөө өгч тэднийг отор хийх газар нутгийн нарийн зураглал, төлөвлөгөөтэй болгох хэрэгтэй.

Залуу малчин бүр сайхан болсон аймгийн нэгдэлтийн эдийн анхдугаар чуулга уулзалтаас гарсан уриалыг хэрэгжүүлэх талаар тодорхой зүйл санаачилсан хийхэд зохино.

Малчин залуучуудын бас нэг зорилт бол мал сүргээ арвин их тэжээл бэлтгэхэд үлгэр жишээчээр оролцох явдал юм.

Өвөл хаврын хатуу хахир цагийг гарз хохиролгүй давах нэг нөхцөл хүрэлцэх хэмжээний тэжээл бэлтгэн ноолдох явдал юм.

Нийд залуучуудын суурь бүр өөрсдийн хүчээр 4-өөс доошгүй тоон өвс бэлтгэн авах шаардлагатай.

Үүний зэрэгцээгээр таана, хөмлийн зоодой сорь хийх, навч цэнэг ургамал хатгаж авах, витаминт тэжээл бэлтгэх зэргээр аль болох өвс бэлтгэхөөгөө шавхан ажиллах нь чухал.

Мал аж ахуйн өвлийн бэлтгэл, прех онь төлийн бэлтгэлийг одоогоос хангах, хариуцсан мал сүргээтээ хээл авахуулах, шинээр хянаа барьж худал гаргах, хуучныг засварлах зэрэг цаг үеийн ажилд салгардлаггүйгээр хүчээ зов хуваарилж ажиллах нь залуу малчин бүрийн хойшлуулашгүй зорилт болж байна.

СУРТАЛЧЛАН ҮЙЛЧЛЭВ

Дэлгэрхаан сумын намын үүрээс ухуулгын бригад гаргаж МАХН-ын Төв Хорооны VIII бүгд хурал, Ардын Их Хурлын чуулган, аймгийн намын XVI бага хурал, сумын 1974 оны эхний хагас жилийн ажлын дүн, цаашид тавих зорилт зэрэг сэдвээр суурьдад хичээл зааж лекц уншиж ухуулга хийлээ.

Энэ бригадынхан хоёр бригадын 225 өрх, 38 суурь орж кино концерт, өргөн хэрэгцээний бараагаар үйлчлэв.

Мөн хадланчдын өдрийн норм, хөлс үнэлгээг, хадланг шимт чанартай үед нь бэлтгэх аргын талаар хадлангийн бригад хэсэгт ухуулга яриа хийсэн байна.

Ш. ЧУЛТЭМДАРЖАА

Социалист УРАЛДААН САНАА НИЙЛСЭН ХҮМҮҮС

Хөдөлмөрийн хамт олны дундаас гарсан санаачилгыг дэмжих нэгэн хурлаас хойш 8 сар гаруй хугацаа өнгөрчээ.

Тэр үед хотын худалдааны трестийн Долгор ахлагчтай хамтын тооцоотой бригад анх байгуулагдаж үйлдвэр худалдааны уялдааг улам бүр ойртуулж хөдөлмөрдөд аль болох хөнгөн шуурхай зөв боловсон үйлчлэх эрхэм зорилго өмнө тавин ажилласан юм.

Өөрийн энэ бригадынхны ажлын амжилт үр дүнтгийн талаар бригадын ахлагч Долгор ярихдаа: "Бид энэ оны эхний хагас жилийн бараа гүйлгээний төлөвлөгөөг 14,2 хувь буюу 133,0 мянган төгрөгөөр, уралдааны үүргээ 104 хувиар буюу 50,7 мянган төгрөгөөр тус тус давуулж биелүүлээ."

Манай худалдан авагч-

дын саналын дэвтэр, захиалга хүлээн авах ширээ ажиллуулж, хүнсний төрөл бүрийн барааны бүрдэл чанарыг худалдан авагчдын нүдний өмнө шалган үзүүлж худалдааг журмыг нэвтрүүлж, үйлчилгээний хүрээг өргөтгөхийн тулд ажлын цагийн цуваа графикаар улирлын чанартай үйлчилж, барааг агуулахаас авахдаа чанарын шалгалт хийж задлан найруулж авах, хүнсний бараагаар зах яармаг гаргах болсон нь үйлчилгээний аятай хэлбэр болж хөдөлмөрдийн талархал хүлээж байна.

Мөн анхан шатны бүртгэлийг тогтмол хөтөлж тооллогыг ойр ойрхон хийлгэдэг болсноор өр дутагдалгүй ажиллаж байна.

Бас СХБ-ын нэг гишүүн нээ дагалдан худалдаг-

чаар ажиллуулж худалдагчийн мэргэжил эзэмшүүлэх зорилготой ажиллаж байгаа юм.

Бригадын гишүүн бүр социалист өмч хөрөнгөд материалыг хуваарилан хариуцаж хадгалалт хамгаалалтыг сайжруулж, хамтын хяналтыг цаг ямагт тавьж ажилдаагс элдэв гологдол гарах явдал багассан гэж ярих.

Бригадын тооцоотой хамт олон гэдэг энэ нэгэн ам бүлд ахмад худалдагч Л. Пунцаг, аймгийн ҮЭ-ийн зөвлөлийн бүгд хурлын гишүүн Д. Цэвэлмаа, тэргүүний худалдагч Д. Аръяа, Ж. Төмөртоого, Касс М. Цогзол, цэвэрлэгч Ц. Гиваа нарын санаа нийлсэн хүмүүс ажилладаг.

Тэд энэхүү амжилтаа улам бататгаж МАХН-ын III их хурал болон БНМАУ-ыг тунхагласны 50 жил, аймгийн худалдааны тэргүүний ажилчдын зөвлөлтөөн утгаж улам их амжилт гаргах нэгдмэл нэгэн санаагаар ажиллаж амжилт олсоор байна.

Ц. МӨНХДАЛАЙ

СОНИРХОЛТОЙ УРАЛДААН БОЛОВ

БНМАУ-ын Мэдээлэл, радио, телевизийн улсын хорооноос эрхлэн Борнуур, Батсүмбэрийн САА-н ажил мэргэжлийн уралдааныг Баянчандманьт төвд сайхан зохион явуулав.

Энэ хоёр САА-нхан эмнэг хангал шуруулж уургалал, унаж булгуулах, гүү саах, цагаан идээ хийх, цагаан идэний таваг засах, майхан барих, гал түлж цай чахах, тракторын тохируулга хийж асааж явах, бөх барилдах, уран сайхны номерууд тоглох зэрэг 13 төрлийн зүйл дээр авхаалж самбаагаа сорив.

Уг уралдаанд хоёр САА-н уралдагчид ерөнхий дүнгээрээ адил оноо авч тэнцэв.

Эмнэг хангал азрага шуруулан уургалж тогтооход Батсүмбэрийн САА-н адуучин залуу Гочоо, эмнэг хангал азрага булгуулахад Борнуурын САА-н адуучин Нацаг, бөхийн барилдаанд Батсүмбэрийн САА-н Дашдэмбэрэл, техник чадамгай эзэмшилтэнд мөн САА-н тракторчин Цэцэнбаатар, майхан барихад Борнуурын САА-н ажилчин Балжинням, гал асааж цай чанахад мөн САА-н Чимгээ, дууны тэмцээнд

мөн САА-н үхэрчин Дэ-лэг нар тус тус түрүүлэв.

Ажил мэргэжлийн уралдаанд түрүүлсэн хүмүүст Мэдээлэл радио телевизийн улсын хорооны дийлэм, мөнгөн шагналогов.

ХАА-н үйлдвэрлэлийн ажилчдын мэргэжлийн иймэрхүү уралдааныг цаашид хөгжүүлж аж ахуйн нууцны хооронд буюу өөрсдийн аж ахуй дээрээ зохион явуулж байх нь ялангуяа залуу ажилчдыг ХАА-н үйлдвэрлэлийн онцлогт сургаж хүмүүжүүлэх үлэмж ач холбогдолтой болох нь энэ уралдаанаас харагдав.

Б. ГАЛСАН

ХОЛБООЧДЫН АМЖИЛТ

Монголын радиогийн 40 жил, холбоочдын өдрийг угтаж аймгийн Холбооны газрын хамт олон 1974 оны эхний хагас жилийн социалист уралдаанд хүн тасаг, салбар бүхэн тодорхой үүрэг амлалт авч ажилласны үр дүнд холбоог хөгжүүлэх, солилцооны төлөвлөгөөг үзүүлэлт бүр дээр нь 1,4—82,5 хувиар дануулан биедүүлж үйлчилгээний ор-

логын төлөвлөгөөг 108,7 хувиар биелүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 60,2 мянган төгрөг, төлөвлөгөөнөөс 40-өөд мянган төгрөгийн ажил илүү хийж хөдөлмөрийн бүтээмжийг 8,7 хувиар дээшлүүлж захиргаа аж ахуйн зардлыг 11,7 хувиар хэмнэн, ашгийн төлөвлөгөөг 130,1 хувиар тус тус биелүүлэв.

Баян—Өнжүүл, Баянца-

гаан, Баянчандманьд 20—100 номерын АТС телефон станц, Мөнгөнморьт, Өндөрширээт сумдад «Сайншанд» радио узел тус тус шинээр тавьж ашиглалтанд оруулав. Төвийн радио телефон тасаг, Борнуур, Бүрэн, Өндөрширээт, Баянцогт, Дэлгэрхаан зэрэг тасаг салбарууд телевиз радио цэгийн тоог олшруулах, засвар үйлчилгээний нь сайжруулах ажлыг хийж байна.

С. ОТГОН

ХАДЛАНГИЙН ТАЛБАЙ ААБ

эхэйн 120-ион өс
сөн С.М. Төмөр-
бузай хүчинтэй 10 ху-
ний дутагттай 1-
ний дутагттай, төлөөлөгч
ний дотор, төлөөлөгч
и өсөөд 9 дараагийн 1-
ний дотор 100-150 ху-
ны өсөөд үзэх зорил-
тын дагуу ажлаа байна.
Нэгдүгээр эдгийн
хүснэгт дараах байдал
тайг шинжлүүлж, өрнө-

Мастер, зд шалгагчдын
семинар зөвлөлгөөн

[illegible]

ХИЩЕДЛИВІЙ ІНТЕРЕСУХ

[illegible]

ХҮРГА БЭЛТЭЛД ЭР НЭЭЖ АНГААР ДН

[illegible][illegible][illegible]

Эмчийн ёс суртахууны асуудал дээр үеэс тодорхойлогдсон боловч өвчтөний ёс суртахууныг хэн ч тодорхойлоогүй байгаа юм. Өвчтөн хүнд янз бүрийн өвчний үед сэтгэл мэдрэлийн өөр өөр өөрчлөлтүүд илэрдэг.

Зүрх судасны өвчнөөр өвчлөгсөд шөнийн шувуу шиг аймхай байхад, ходоодны өвчтэй үед зочромтгой, шаналсан, сэтгэлээр унасан байдал мэдэгдэнэ.

Хүүхэд, насанд хүрэгчдээс өөрөөр өвчилдөг. Насанд хүрэгсэд, хүүхэд адил аймхай уйлалттай болдог ёс бий.

Анх удаа өвчлөгсдөөс ужиг өвчтэй хүмүүс тайван байдалтай байдаг.

Эрэгтэйчүүдээс эмэгтэйчүүд шаналгаа даахдаа сайн. Эдгээр олон тохиолдлууд эмч нарт хүн бүрийн онцлогийг нээх аргатай байхыг шаардана.

Харин эмчид тохирх үүлхүүр гэж байж болохгүй. Яагаад гэвэл:

Эмч хүн ямагт бүхэнд хүрэлцээтэй байхыг мөргөжлийн онцлог нь шаарддаг. Тайван байдалаа өөрчлөхгүй, дотоод сэтгэлийнхээ хүчийг хадгалан, сэтгэлийн хөдөлгөөнөө давж, анхаарлаа өвчтөнд хөвчлөн төвлөрүүлэх нь тийм ч амаргүй.

Би саяхны нэгэн тохиолдлын тухай дурьдъя.

Нэгэн хүн шалшавхайдсаар үсрэн орж ирээд сандал дээр ухасхийн сууж, нойтон малгайгаа тавиур руу шидэв.

Би малгайг нь өлгөөд шал руу зааж,

—Поликлиникт орохын өмнө гутлаа арчиж болох байсан гэв.

Тэрээр шавхай руу харж мөрөө хавчисхийж «Ийм жижиг зүйлд анхаарах хэрэг байна уу? Цэвэрлэгчийн ажил» гэсэн байртай байв.

Хадааснаас ямар нэгэн эм гаргаж стол дээр тавиад,

—Хоёр өдөр уулаа, нэмэр

алга, аллахол бичиж өг гэв. Би эм рүү нь харсан нь аялалын байв.

Тэхээр нь би: —Танд анальгин ч, аллахол ч хэрэггүй, сувилгааны чанартай хоол л хэрэгтэй гэлээ.

Өвчтөний цамц нь хиртэй, бас өөрөө лав сар усанд ороогүй мэт байв.

—Эмчид үзүүлэхдээ усанд орж угаасан дотуур хувцастай байвал зүгээрсэн гэв.

Тэр лийжакаа засаад ээрлэгдүү дуугаар,

—Сэжиглэж байна уу?

Хувцасны хяргийг харцагааж, харин гэдэс юу болж байгаад зовдоггүй юм уу? Бусдад аллахол бичээд надад юугийг нь харамлав гээд, баяртай ч гэлгүй гарч явав.

ЭМЧ ӨВЧТӨНИЙ ЁС СУРТАХУУН

Миний сэтгэл тавгүй болж өвчтөн үзэж байхад толгойд «Сэжиглэж байна уу», Та нар зовохгүй байна уу? Бусдад бичээд гэж байн байн болдоглож байв.

Энэ өвчтөнийг би мэддэг байв. Өндөр цалинтай «МАЗА»-ийн жолооч хэрсүүдүү боловч хулигаанд тооцогдохгүй.

Тэгнэл түүний араншинг юугаар тайлбарлах вэ?

Өвчний эсрэг үйлдэл үү? Яагаад эмч рүү хандав? Оюутан ахуй цагт биднийг зөвхөн өвчтөнд зөнийг өгөх талаас нь хандаж бай гэж сургадаг.

Өвчин бүсэд гамшигийн адил заримы ньзанг зөөлрүүлж, заримыг нь давлуун болгодог.

Сүүлчийн нь миний өвчтөнд тохиолдсон бололтой. Анх удаа өвчлөгсөд ингэж аашлах нь ховор байдаг, тэгээд ч түүний биеийн байдал хүндгүй, аюултай биш байсан юм. Эмч нараас хувцасаа нимбай өмсч төлөв аятайхан байхыг шаарддаг.

Энэ шаардлагыг өвч

төнд нэгэн адил тавьж болохгүй гэж үү? Усанд оролгүй хиртэй хувцастай ирсэн нь өвчний шинж биш, бүдүүлгийн шинж учраас өвчний биш өвчтөний буруу. Тэр сэжиглэж байна уу гэж асуусан сонирхолтой хэрэг шүү. Өвчнөөс болсон янз бүрийн бохир байдалд эмч нар бүрэн дархлагдсан хүмүүс.

Өвчтөн бүр ичиг эвгүйрхдэг, харин эмч нар аль болохоор чөлөөтэй байлгахыг хичээж элдэв эвгүй байдлыг анхаарахгүй мэт байдаг, тэр байдал нь өвчний эдгээртэй холбоотой бол сэжиглэж байтугай баярлах тохиолдол ч таараалдаг.

Эмч нар бол сэжиглэхийг мэддэггүй юм.

Гэвч үзүүлэхээр ирсэн өвчтөний соёл биш байдал нь эвгүй сэтгэгдэл төрүүлж, эмчид хүндэтгэлгүйгээр хандсан мэт ойлголт авахад хүрдэг.

Ариун цэвэрч биш байдлын улмаас биеийн арьсан дээр зарим өвчний үед илэрлэг тууралтууд, өнгө өөрчлөгдөх зэрэг шинж тэмдгүүдийг бүдгэрүүлэхэд хүргэдэг.

Хүн эрүүл мэндээ ноцтойгоор өөрчлөгдсөн үед эм, зөвлөлдөө авч эрүүлжих найдвартайгаар эмчид очдог.

Эмчид үзүүлэх нь чухал учир түүнд зорвуд бэлтгэх хэрэгтэй. Зарим үед эмчийг үзлэг хийх үед нь дуудах, үзлэгийн өрөөнд зөвшөөрөлгүй орох, билет тараах, татвар хураах зэргээр үзлэгийн өрөөнийг эмхгүй явдал нь өвчтөнд муу нөлөө үзүүлдэг.

Киевийн 22 дугаар Поликлиникт «Чимээгүй байна уу? үзлэг явагдаж байна» гэсэн гэрлэн дохио ажилладаг.

Энэ нь үзүүлэгчдэд энд чухал ажил явагдаж бай-

гаа учир дэглэмтэй хүндэтгэлтэй хандахыг сануулсан хэрэг юм.

Өвчтөн хүн эмчийн тайван байдлыг алдагдуулахгүй байх нь чухам дээрээ өвчтөний тэвдэх зовохын эсрэг чухал хүчин зүйл болдог.

Харьцаанд хөндий байдал бий болох нь тэр болгон мэдэгдэхгүй нилээд тохиолдолд өвчтөн өөрийн өвчний тухай нэгэн ойлголттой байхад эмч өөр ойлголттой байдаг. Энд өвчтөн хүн нэгэн зүйлийг ойлгох шаардлага гардаг. Гаднах шинж тэмдэг нь энэ талаар мөргөжээгүй хүнийг төөрөгдүүлэх нь илүү байдаг ба өвчинг зөв таньж эмчилэхэд тусгай мэдлэг шаардлагддаг. Дээрх жолоочийн адил өвчин нь өөр өөр байсаар байтал хэн нэгэнд ямар нэгэн эм таарснаас түүнийг бичүүлэхийг шаардах нь буруу юм. Үүнээс л эерийл үүсдэг. Өвчтөн өөр эмчид очно, түүнээс дараагийнх руу явна, нөгөө эмээ зүгээр л бичиж өгөхийг гуйсан мэт байдаг боловч уур хорсол нь багтаж ядан нуугдаж байдаг учир татгалзсан хариуг дуулсны дараа хаалга шидэж гардаг.

Үзүүлэхээр ирэхдээ эвхөн л эмчдээ итгэх итгэл найдвар өвөртөлж эмчийн өөрийн зовлон шаналгааг хуваалцах хамгийн дотоо хүн гэж үзэх хэрэгтэй. Өвчтэй хүний шаналгааг тэвчээртэй сонсож чадах нь эмч хүний их соёл юм. Үүнээс дуутуугүй нэг соёл бол өвчтөн өөрийн байдлаа ярих тайл барлаж чадах чадвар болно. Дээр дурдсан Киевийн поликлиникт «Та эмчид ирэхийн өмнө эмчийн асуултанд өгөх хариултаа сайн бод, хэрэв марчиг гээд байвал өөрийн дэвтэртээ тэмдэглэсэн ч болно» гэсэн плакат өлгөөтэй байдаг. Ингэж л тодорхой хариулт өгөх хэрэгтэй юм. Эмч нараас

өвчтөнөөс асуух асуултын дэс дараа эрт бий болсон, эхлээд ерөнхий байдалтай танилцдаг Нас, мэргэжил, ажлын газар, энэ нь заримдаа хэлбэрдэж байгаа мэт санагддаг. Гэвч дээрх асуултаас өвчтөний амьдрал, хөдөлмөрийн байдал мэдэгдэж өвчинд нөлөөлж болох анхны шалтгаан нь ерөнхий боловч багцаа мэдэгдэж эхэлдэг гэдгийг үгүйсгэж болохгүй. Дараа нь хэвшил болсноо чинь өвдөж байна? хэзээ яаж өвдөж эхэлсэн бэ? цаашаа яаж хүндэрсэн, юунаас боллоо гэж та үзэж байна? урьд ямар өвчнөөр өвдөж байсан бэ? гэх зэргээр асуулт тавигддаг.

Асуултыг хир зэрэг зөв хариулна. Тэр хэмжээгээр өвчнийг танихад тусалж байгаа юм. Зарим хүн өвчнөө хэт хүндрүүлж ярих, зарим нь хөнгөнөөр ярих явдал гардаг, аль нь ч эмчийг төөрөгдүүлж болзошгүй юм.

Заримдаа өвчтөн бага ч гэсэн ямар нэгэн зүйлийг нуухыг оролддог. Энэ нь өвчинтэй холбоотой зүйл бол өвчнийг таних, эмчлэх бололцоог багасгадаг. Үзлэгийн өрөөнд өвчтөнийг чөлөөтэй яриулах бололцоог багасгадаг. Үзлэгийн өрөөнд өвчтөнийг чөлөөтэй яриулах бололцоог хангаад нууцыг нь хадгалж байх нь эмчийн ариун үүргийн нэг билээ. Зарим өвчтөн үзүүлэхдээ ичиг зовсноос зүрх дохиох, амьсгаадах, нүүр улайх байдал бий болдог. Энэ нь бас эмчийг төөрөгдүүлдэг. Иймээс биеэ барьж тайван байх нь чухал.

Учир нь өмнө чинь зөвхөн танд туслах үүрэгтэй, мэдлэг туршлага бүхий эмч хүн байгааг мартаж болохгүй.

«Здоровье» сэтгүүлийн 1974 оны нэгдүгээрт дэд эрдэмтэн П. Е. Бейлиний бичсэнийг товчлон хөрвүүлсэн Б. ГАЛСАНДОРЖ

Ариун цэврийн сарын ажилд

ЖИГД САЙЖРУУЛЪЯ

Эрдэнэсант сум ариун цэврийн сарын ажлыг удирдан зохион байгуулах сумын комисс байгуулж албан байгууллага, бригад, цех үйлчилгээний газрууд тусгай төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Саяхан ариун цэврийн үзлэгийг 20 гаруй албан байгууллага, 100 гаруй өрхийг хамран хийж орон сууц, муу усны нүх, бие засах газруудад ариутгал хийж ялаа, жоом устгах ажил зохиов.

Сумын клубээс мал аж ахуйн 2 бригад, сүү тосны 4 тасаг, 30 гаруй суурин ухуулгын бригад гарган ажиллуулж,

ариун цэврийн сэдвээр гэгээрлийн хурал хийлгэж эм бараагаар үйлчилжээ.

Түүнчлэн ариун цэврийн үзлэгээр сумын ХБА, хүний их эмчийн салбар, ТАА-н гуанз, цэцэрлэгүүд, засварын цех зэрэг газруудын барилгын орчин тойрны цэвэрлэгээ соёлжилтоор жигд сайн байв.

Гэтэл талхны газар, нэгдлийн контор, зочид буудал зэрэг газар өрөө тасалгааны цэвэрлэгээ муу, шороо тоос ихтэй, эд материал, сав суулганы цэвэрлэгээ, угаалга хангалтгүй, мөн Баян-уул, Алтан-уул, Цээл-зэ-

рэг сүү тосны тасгуудын ариун цэвэр муу, ариутган цэвэрлэх материал хүрэлцээгүй, орчин тойрон нь бохир, муу усны нүх байхгүй, тэрч байтугай зарим саальчдын хувийн ариун цэвэр хангалтгүй байгаа дутагдал үзэгдэв. Иймд сумын ариун цэврийн комисс, хүн эмнэлэг дээрх дутагдалд дүгнэлт хийж соёлжилт ариун цэврийн хэмжээг жигд сайжруулах явдал чухал байна.

Ялангуяа хадлангийн бригад, хэсгийн орчны ариун цэврийг эрс сайжруулж муу усны нүх, бие засах газартай болгож байнга ариутган цэвэрлэж байх шаардлагатай байна.

Н. НАНЖИД



Эхний хагас жилд

Аймгийн Хүнсний үйлдвэрийн хамт олон энэ оны эхний хагас жилийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөг 128 хувь биелүүлсний дотор талх, гоймонгийн цехүүд төлөвлөгөөгөө 16,2—63 хувиар давуулан биелүүлжээ. Мөн 7 дугаар сарын эхний 20 хоногийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөг 110,7 хувиар биелүүллээ.

Ц. ДОРЖ

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д. ТОВУУ



Суданд, жамс ногооны консервын заводыг ЗХУ-ын тусламжтайгаар барьж ашиглалтанд оруулжээ. Энэ завод жил бүр чанартай олон сая бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргадаг. ЗУРАГ ДЭЭР: Заводын нэгэн цехэд ТАСС-ын гэрэл зураг